**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2023/09/НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2023 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn<br>Аудитор: Б.Одхүү<br>Утас: 70584207 Цахим хаяг:Odkhuu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ....................
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ....................
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....................
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....................
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ....................
4. Аудитын тайлан ....................
4.1 Ерөнхий зүйл....................
4.2 Материаллаг байдал....................
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт ....................
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....................
5. Аудитын илрүүлэлт ....................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ....................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.03.24 № 481

танай ____________-ны №______________-т

БАЯНТҮМЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Э.НАРАНГАРАВ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баянтүмэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтүмэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Баянтүмэн сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 12/26 дугаар тогтоолоор хангалттай гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

011020501

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 881,388.5 | 664,335.3 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 366,887.7 | 250,657.9 |
| 33 | АВЛАГА | 215,937.1 | 210,657.6 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 287,063.7 | 185,482.3 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 11,500.0 | 17,537.4 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,289,796.9 | 2,473,179.1 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,289,796.9 | 2,473,179.1 |
| 39200 | Биет хөрөнгө | 3,062,068.8 | 2,286,909.4 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 227,728.1 | 186,269.7 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | **4,171,185.4** | **3,137,514.4** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,652.5 | 3,182.5 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,652.5 | 3,182.5 |
| 41300 | Өглөг | 2,652.5 | 3,182.5 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,168,532.9** | **3,134,331.9** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,168,532.9 | 3,134,331.9 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 964,283.1 | 642,586.8 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 964,283.1 | 642,586.8 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 2,460,703.6 | 2,258,158.3 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 743,546.2 | 233,586.8 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | **4,171,185.4** | **3,137,514.4** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,625,765.6** | **2,389,022.5** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 82,601.7 | 383,846.5 |
| 110 | Орлогын албан татвар | 24,645.9 | 169,260.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 24,645.9 | 179,226.1 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | 0.0 | -9,965.4 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 988.0 | 101,691.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 56,967.8 | 112,894.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 611,524.8 | 1,116,342.5 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 581,174.8 | 909,742.5 |
| 122 | Тусламжийн орлого | 30,350.0 | 206,600.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,931,639.2 | 888,833.5 |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,052,546.2** | **1,083,669.6** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,052,546.2 | 1,083,669.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,176,283.0 | 1,064,134.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,188,602.2 | 371,031.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 154,179.6 | 46,150.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 61,912.4 | 76,957.4 |

| | | | |
|---|---|---|---|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 82,993.0 | 41,785.7 |
| 2105 | Норматив зардал | 191,677.2 | 22,214.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 69,559.7 | 21,702.7 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,761.6 | 61,580.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,026.4 | 7,238.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 415,571.0 | 415,472.3 |
| 211 | ХҮҮ | 0.0 | 0.0 |
| 212 | ТАТААС | 0.0 | 0.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 876,263.2 | 19,534.9 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 0.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 573,219.4 | 1,305,352.9 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 0.0 | 0.0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 162,927.5 | 2,282,764.5 |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **410,291.9** | **-977,411.6** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,777,811.6 | 0.0 | 3,777,811.6 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -19,570.6 | 0.0 | -19,570.6 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,758,241.0 | 0.0 | 3,758,241.0 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 |
| 7 | Өмчид гарсан өөрчилөлт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 410,291.9 | 0.0 | 410,291.9 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,168,532.9 | 0.0 | 4,168,532.9 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,168,532.9 | 0.0 | 4,168,532.9 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -1,520,112.7 | 0.0 | -1,520,112.7 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,648,420.2 | 0.0 | 2,648,420.2 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | -977,411.6 | 0.0 | -977,411.6 |
| **20** | **2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **3,134,331.9** | **0.0** | **3,134,331.9** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код : | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,287,065.9** | **1,665,546.4** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 82,601.7 | 383,846.5 |
| 110 | Орлогын албан татвар | 24,645.9 | 169,260.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 24,645.9 | 179,226.1 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | 0.0 | -9,965.4 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 988.0 | 101,691.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 56,967.8 | 112,894.0 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 2,778.8 | 3,931.8 |
| 1181 | Газрын төлбөр | 54,189.0 | 108,962.2 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 318,094.5 | 392,866.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 257,394.5 | 186,266.4 |
| 122 | Тусламжийн орлого | 60,700.0 | 206,600.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,886,369.7 | 888,833.5 |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,778,472.1** | **859,793.5** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,778,472.1 | 859,793.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,894,168.2 | 840,258.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,187,763.8 | 371,031.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 154,179.6 | 46,150.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 61,912.4 | 76,957.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 89,268.6 | 40,196.3 |
| 2105 | Нормативт зардал | 181,592.0 | 22,210.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 83,904.7 | 22,022.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,761.6 | 61,580.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,026.4 | 7,458.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 123,759.2 | 192,650.1 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 884,303.9 | 19,534.9 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 508,593.8 | 805,752.9 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 264,803.6 | 816,432.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 264,803.6 | 816,432.7 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 234,453.6 | 816,432.7 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 30,350.0 | 0.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -264,803.6 | -816,432.7 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -66,000.0 | -105,550.0 |
| 14 | Бусад эх үүсвэр | 0.0 | 0.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 66,000.0 | 105,550.0 |
| 24 | ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР | 0.0 | 0.0 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 0.0 | 0.0 |
| VIII | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **177,790.1** | **-116,229.8** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 189,097.5 | 366,887.7 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 366,887.7 | 250,657.9 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Тайлангийн үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,802,874,8** | **1,591,756.7** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **705,537.2** | **676,279.9** |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 691,745.4 | 663,212.2 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 384,202.4 | 369,052.8 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49,375.7 | 46,150.1 |
| Байр ашиглалтгай холбоотой тогтмол зардал | 78,513.2 | 76,957.4 |
| Хангамж, бараа материалын зардал | 18,301.4 | 18,038.3 |
| Нормативт зардал | 31.5 | 0.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 28,870.8 | 26,223.1 |
| Томилолт, зочны зардал | 4,046.5 | 4,028.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,757.5 | 4,886.2 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 122,646.4 | 117,875.3 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,791.8 | 13,067.7 |
| Бусад урсгал шилжүүлэг | 13,791.8 | 13,067.7 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 991,337.6 | 809,926.8 |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 106,000.0 | 105,550.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,802,874.8** | **1,565,854.4** |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.0 | 0.0 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,185,623.4 | 1,273,941.3 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 390,601.4 | 85,313.2 |
| ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ | 226,650.0 | 206,600.0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 168,507.8 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 141,959.2 |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 0.1 | 0.1 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Тайлангийн үзүүлэлт | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **111,576.8** |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 111,576.8 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 109,192.5 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,979.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 22,158.0 |
| Нормативт зардал | 22,210.8 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 2,305.0 |
| Томилолт, зочны зардал | 57,552.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,572.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 415.2 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,384.2 |
| Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,384.2 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **111,457.1** |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 111,457.1 |
| нийт цэвэр мөнгөн гүйлгээ | -119.6 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 119.6 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40.5 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд: Хоршоо хөгжүүлэх сангийн үр дүнгийн тайланд эргэн төлөгдсөн авлагыг тусгаж буруу илэрхийлснийг залруулсан.

Аудитаар нийт 243.4 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 243.4 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Сумын төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Сумын татварын орлого нийт дүнгээрээ 100.9 хувиар биелсэн боловч Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 55.8 хувь буюу 79.5 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “*Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй*”, 6.2.2-д “*жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх*”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "*хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Сумын төсвийн орлогыг үзүүлэлт бүрээр бүрэн төвлөрүүлэх.

2. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагатай холбоотой асуудал.

*Илрүүлэлт:*

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн 32.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байна. Авлагыг барагдуулахаар Шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлсэн ч 2 иргэний 21.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл өмнөх оноос буураагүй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан “*Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам*”-ын 3.4.5 дахь “*зээл зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх*”, 3.4.11 дэх “*сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах.

3. ОНХС-гийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

*Илрүүлэлт*:

ОНХС-гийн хөрөнгөөр 991.3 сая төгрөгийн 46 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. Үүнээс "Мал эмнэлгийн байр барих" 70.0 сая, "Нэгдсэн халаалтын зураг төсөв" 60.0 сая, "Бэлчээрийн менежмент сайжруулах" 12.0 сая төгрөг нийт 142.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь *“Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”*, 41.2.7-д *“хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”* гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтийг хангуулж ажиллах.

4. Өр төлбөртэй холбоотой асуудал

*Илрүүлэлт*:

Баянтүмэн хөгжил ОНӨААТҮГ нь жилийн эцэст татварын байгууллагад төлөх 0.6 сая төгрөгийн өрийг бүрэн барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”* гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Татварын өр төлбөрийг бүрэн барагдуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 3 | 27.0 | | | 3 | 27.0 | 3 | 27.0 | | | | |
| ИТХ | 1 | 0.3 | | | 1 | 0.3 | 1 | 0.3 | | | | |
| ТТЗ | 1 | 40.5 | | | 1 | 40.5 | 1 | 40.5 | | | | |
| Дүн | 5 | 67.8 | | | 5 | 67.8 | 5 | 67.8 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сумын ИТХ | 1 | 0.2 | | | 1 | 0.2 | | | | | | |
| Сумын ЗДТГ | 2 | 6.0 | 1 | 0.5 | | | 1 | 5.5 | | | | |
| ТТЗ | 3 | 243.4 | | | | | 3 | 243.4 | | | | |
| Дүн | 6 | 249.6 | 1 | 0.5 | 1 | 0.2 | 4 | 248.9 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| ЗДТГ | 1 | 124.5 | | | 1 | 124.5 | | |
| ТТЗ | 1 | 887.1 | | | 1 | 887.1 | | |
| Дүн | 2 | 1011.6 | | | 2 | 1011.6 | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Нийт дүн | 2 | 1011.6 | | | 2 | 1011.6 | | |